

***“Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас
хэрэгжүүлсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт”
нийцлийн аудитын тайлан***



***Урвалж оношлуур нь өндөр үнэтэйгээс олон нэр төрлийн шинжилгээ
хийхэд төсөв хөрөнгийн хэмжээ хүрэлцдэггүй байна***

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	3
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	4
	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	4
	Үндсэн мэдээлэл	5
Газрын дарга Б.Алтанзул	Бүлэг 1. Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээг “МУ-ын 2013 оны Төсвийн тухай хуульд төсвийн тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай” хуулиар баталжээ	
Аудитын менежер З.Ариунзаяа	1. Төсвийн байнгын хороо төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээг баталжээ	6
Ахлах аудитор Ш.Энхтайван	2. Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээг 2013 ондоо багтаан хэрэгжүүлэхээр ажлаа зохион байгуулж чадаагүй байна	6
Шинжээч Л.Нямтөмөр Г.Ганбаатар	3. ЗГХЭГ болон ХААГ нь Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолыг зөрчиж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна	8
	Бүлэг 2. ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлттэй уялдаагүйгээс зарим хөрөнгө оруулалтын үр дүн гарахгүй байна	
2015 оны 3 дугаар сар	1. Урьдчилсан судалгаа дутуугаас тоног төхөөрөмжийг дахин хуваарилжээ	9
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү.	2. Урвалж оношлуур нь өндөр үнэтэйгээс олон нэр төрлийн шинжилгээ хийхэд төсөв хөрөнгийн хэмжээ хүрэлцэхгүй байна	
www.audit.mn	Бүлэг 3. Эмч, мэргэжлийн техникийн ажилтнуудыг урьдчилан бэлтгээгүй, иж бүрдэл дутуу, урвалж оношлуурын өртөг өндөр, урсгал зардал нэмэгдсэнээс тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглаж чадахгүй байна	10
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261749, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	1. Эмч, техникийн ажилтан байхгүйгээс өндөр үнээр худалдан авсан тоног төхөөрөмжөө ашиглахгүй байна	11
Хаяг:	Дүгнэлт	13
	Зөвлөмж	14
	Холбогдох байгууллагын санал	
Үндэсний аудитын газар Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-3	Хавсралт № 1	15
Засгийн газрын IY байр Улаанбаатар хот 15160 Монгол Улс	Хавсралт № 2	16

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
МУ	Монгол Улс
НЭ	Нэгдсэн эмнэлэг
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХААХЭЗГ	Худалдан авах ажиллагаа хууль эрх зүйн газар
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭУГ	Эрсдэлийн удирдлагын газар
ЭХЭМҮТ	Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Аудит хийх үндэслэл

Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны “Аудитын сэдэв батлах” тухай 3 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2015 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцад тусгагдсан аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн төлөвлөлт, хэрэгжилтэд аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийнэ. Үүнд:

- Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээ МУ-ын хууль тогтоомжид нийцсэн эсэх;
- Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний төлөвлөлт, худалдан авалт, зарцуулалт оновчтой эсэх;
- Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй байгаа эсэх.

Аудитын хамарсан хүрээ

Аудитыг батлагдсан хуваарийн дагуу Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Эрүүл мэнд, спортын яам, аймгуудын Нэгдсэн оношлогооны төвүүд болон Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн гүйцэтгэсэн 2013 оны ажлын тайлан мэдээлэл болон бусад холбогдох материалд тулгуурлан гүйцэтгэв.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу холбогдох горимоор нотлох зүйл цуглуулж, дүн шинжилгээ хийн аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулж, холбогдох мэдээ судалгаа, тайлан, тайлбарыг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитын зорилттой холбогдуулан Төсвийн тухай хууль, Монгол Улсын 2013 оны төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Эрүүл мэндийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УИХ, Засгийн газрын тогтоол, дүрэм, журмыг шалгуур болгон ашиглав.

Үндсэн мэдээлэл:

МУ-ын 2013 оны Төсвийн тухай хуульд Засгийн газрын үйл ажиллагааны буюу шинэчлэлийн хөтөлбөрт тусгагдсан зорилтыг хангах үүднээс хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн хэмжээг 50.0 тэрбум төгрөгөөр баталжээ.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2013 оны 2 дугаар тогтоолоор тус хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр төрөл, тоо хэмжээ, төсөвт өртгийн хэмжээг баталж, холбогдох арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосон байна.

			/сая.төг/
№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ	Хийгдэх ажлууд	ТБХ-ны тогтоолоор баталсан төсөвт өртөг
1	Замын цагдаагийн торгуулийг бэлнээр төлдөггүй, тасалбарын систем нэвтрүүлэх	350 ширхэг гар компьютер, хэвлэгч машин худалдан авах, програм хангамж сүлжээг бий болгох	1,800.7
2	Иргэдэд шаардлагатай лавлагаа, мэдээлэл өгөх автомат машинуудыг байрлуулах	120 автомат киоск машинуудыг Улаанбаатар хот болон 21 аймгийн төвд байрлуулах	2,000.0
3	Төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох	Шуудангийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй шуурхай болгох	1,929.0
4	Аймгийн төвүүдэд битүү зах, худалдааны төв барихад хөрөнгө оруулах	Ховд, Баян-Өлгий, Увс аймгуудад худалдааны битүү төв барих	9,768.0
5	Аймгуудын нэгдсэн оношлогооны төв бий болгох	11 аймгийн оношлогооны төв байгуулах, Улаанбаатар хотод эх, ураг, нярайн тусламж үйлчилгээний төв байгуулах	25,977.1
6	Үндэсний цэцэрлэгт хүрээлэнд хөрөнгө оруулалт хийх	Гадна спортын цогцолбор болон дугуй, цана, гүйлтийн хосолсон зам, дугуйн зогсоол байгуулах	5,335.4
7	Залуучуудын үйлчилгээний цогцолбор босгох	Хүүхэд залуучуудын төвийг иргэд чөлөөт цагаа гэр бүлийн хамт өнгөрөөх үйлчилгээний төв болгоход хөрөнгө оруулалт хийх	3,189.0
НИЙТ			49,999.2

Үүнээс Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “эх орондоо чанартай оношлогоо, эмчилгээ хийлгэх боломжийг бүрдүүлэх”, “Төрийн болон хувийн хөрөнгө оруулалтаар оношлогооны томоохон төвийг байгуулж, эх орондоо бүрэн оношлуулах нөхцөлийг бүрдүүлэх” гэсэн зорилтын хүрээнд 11 аймгийн нэгдсэн эмнэлэг болон Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвд эрүүл мэндийн оношлогооны төв байгуулахад 25.9 тэрбум төгрөг зарцуулахаар тусгасан байна.

Хөтөлбөрт хамрагдсан аймгуудын судалгааг үзүүлбэл:

			/сая.төг/
Аймгуудын нэгдсэн оношлогооны төв бий болгох	Архангай, Баян-Өлгий, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Завхан, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгуудад оношлогооны төв байгуулахад тоног төхөөрөмж нийлүүлэх		21,577.0
	Дээрх 11 аймгуудын барилгын ажлын төсөвт өртөг		1,980.0
	Улаанбаатар хотод эх, ураг, нярайн тусламж үйлчилгээний төв байгуулахад тоног төхөөрөмж нийлүүлэх		2,219.1
	ЭХЭМҮТ-ийн засвар тохижилтын ажил (Катетерийн лаборатори)		201.0
	Нийт		25,977.1

/11 аймагт нийлүүлсэн тоног төхөөрөмжийн судалгааг хавсралт №1-ээр үзүүлэв./

Энэ хөтөлбөрийн хүрээнд тоног төхөөрөмжийн санхүүжилтэд 23,796.1 сая төгрөг төсөвлөж, 21,447.1 сая төгрөгийн гэрээ байгуулж, санхүүжүүлсэн ба харин засварын ажлын зардалд 2,181.0 сая төгрөг төсөвлөж, 1,875.8 сая төгрөгийн гэрээ байгуулан

1,679.7 сая төгрөг санхүүжүүлж, төсвийн дутагдлаас шалтгаалан 196.2 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй байна. / Санхүүжилтийн судалгааг хавсралт №2-оор үзүүлэв./

Бүлэг 1. Оношлогооны төв байгуулах төслийг “МУ-ын 2013 оны Төсвийн тухай хуульд төсвийн тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай” хуулиар баталжээ

УИХ-ын Төсвийн байнгын хороо төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээг баталжээ

Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт заасан 2013 онд хэрэгжүүлэх шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах 50.0 тэрбум төгрөгийг 2013 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусган батлахдаа Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.4¹-д, 29 дүгээр зүйлийн 29.4²-д, 33 дугаар зүйлийн 33.2.6³-д заасан төсвийн тухай хуулийн заалтад хамааруулахгүй байхаар “Монгол Улсын 2013 оны төсвийн тухай хуульд төсвийн тухай хуулийн зарим заалтыг хамааруулахгүй байх тухай хууль”, хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, төсөвт өртөг, санхүүжилтийн хэмжээг УИХ-ын Төсвийн байнгын хороо 2013 оны 1 дүгээр улиралд багтаан батлахаар УИХ хуульчилсан байна.

Оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээг 2013 онд багтаан хэрэгжүүлэхээр ажлаа зохион байгуулж чадаагүй байна

Ерөнхий сайдын 2013 оны 109 дүгээр захирамжаар шинэчлэлийн хөтөлбөрийн худалдан авах ажиллагааг зохион байгуулах, бараа нийлүүлэлт болон ажил, үйлчилгээг гүйцэтгэх явцад хяналт тавьж, үр дүнг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт, ЗГХЭГ-ын даргын 2013 оны 101 дүгээр тушаалаар шинэчлэлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын эрхийг ХААГ-ын даргад шилжүүлсэн байна.

Оношлогооны төв байгуулах төслийг тоног төхөөрөмж нийлүүлэх 9 багц, засварын ажлын 1 багц нийт 10 багцад хуваан, тоног төхөөрөмжийн гүйцэтгэгч шалгаруулах тендерийг 2013 оны 7 дугаар сарын 10-наас 8 дугаар сарын 12-ны өдөр хүртэл хугацаанд зарлаж, 9 дүгээр сарын 5-ны өдөр үнэлгээг оролцогч байгууллагуудад ХААГ танилцуулсан байна.

Тендерт оролцогч байгууллагуудаас тендерийн үнэлгээнд гомдол гарснаас СЯ-ны ТНБД-ын 2013 оны 5/5300 албан бичгийн дагуу 30 хоног сунгажээ.

Мөн ЭХЭМҮТ-ийн зүрхний катетерийн лабораторын засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг 2013 оны 10 дугаар сарын 14-ний өдөр зарлаж, ороцлогч "Пайрлинк" ХХК нь татварын өртэй шалтгаанаар тендер шалгаруулалт хүчингүй болсноос хэрэгжээгүй байна.

ХААГ-ын зарласан нээлттэй тендер шалгаруулалтад гомдол гарсан, тендерт шаардлага хангасан оролцогч ирээгүйгээс тендер шалгаруулалт хүчингүй болж төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширах нөхцөл болжээ.

Оношлогооны тоног, төхөөрөмж нийлүүлэх ажлыг Монгол эм импекс, Чоно гол трейд, Сүвэн уул ХХК-иуд тус бүр 1 багцыг, Моносфарм, Эйч энд эйч, Сетунари ХХК-иуд тус бүр 2 багцыг гүйцэтгэхээр 2013 оны 10 дугаар сарын 7-нд гэрээ байгуулжээ.

¹ “төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын болон концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах”

² “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана”

³ “хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/”

*Оношлогооны тоног, төхөөрөмж нийлүүлэхээр шалгарсан ААНБ-ын судалгааг
хүснэгтээр үзүүлбэл:*

№	Гүйцэтгэгч	Нийлүүлэх тоног төхөөрөмж	Гэрээ		Гэрээний дүн
			эхлэх	дуусах	
1	Монгол эм импекс концерн ХХК	Дурангийн тоног төхөөрөмж	2013.10.07	2013.12.30	6,472.9
2	Чоно гол трейд ХХК	Шүд, нүд, чих, хамар, хоолойн тоног төхөөрөмж	2013.10.07	2014.01.04	887.0
3	Сүвэн уул ХХК	Эх нярайн тоног төхөөрөмж	2013.10.07	2014.01.06	397.2
4	Монос фарм трейд ХХК	Компьютер томографи	2013.10.07	2014.03.06	6,265.0
5	Монос фарм трейд ХХК	Ангиографи	2013.10.07	2014.03.06	1,780.0
6	Эйч энд эйч ХХК	Суурин дижитал ЭХО аппарат	2013.10.07	2013.11.23	945.9
7	Эйч энд эйч ХХК	Рентген зургийн тоног төхөөрөмж	2013.10.07	2013.11.23	1,199.1
8	Сетунари ХХК	Тархины доплеграфи	2013.10.07	2014.01.08	660.0
9	Сетунари ХХК	Лабораторийн тоног төхөөрөмж	2013.10.07	2014.01.08	2,840.0
Нийт					21,447.1

Дээрх тоног төхөөрөмжийг 2013 онд багтаан нийлүүлэхээр 3 гэрээ, 2014 онд нийлүүлэхээр 6 гэрээ байгуулсан бөгөөд 2013 онд тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ хийсэн "Монгол эм импекс концерн", "Эйч энд эйч" ХХК-иуд хугацаандаа, 2014 онд нийлүүлэх гэрээтэй Сүвэн уул ХХК, Сетунари ХХК, Чоно гол трейд ХХК-иуд 2013 оны 12 дугаар сарын 24, 25, 26-ны өдрүүдэд тоног төхөөрөмжүүдийг тус тус хүлээлгэн өгсөн байна.

Тендерт оролцогч байгууллагуудаас тендерийн нөхцөл, тоног төхөөрөмжийн тодорхойлолтыг тодруулах, түүний талаар удаа дараа санал, гомдол гаргаж байсан бөгөөд ЗГХЭГ-т техникийн тодорхойлолтыг хэрхэн боловсруулсан талаарх баримт бичиг байхгүй байна.

"Мед энд стар эрдэнэ" ХХК ба "ЭМЖЖ" ХХК-иудын түншлэлийн "ЭМЖЖ ХХК нь татварын өглөгтэй байснаас тендерийн шалгуурыг хангахгүй болсон, "Медимпекс" интернэшнл ХХК нь 2010 оны 4 дүгээр улирлын аудитаар баталгаажсан тайлангийн оронд 2010 оны 3 дугаар улирлын тайланг хүргүүлсэн, "Эйч энд Эйч" ХХК-ын борлуулалтын орлого нь тендерийн шалгуурт заасан борлуулалтын орлогын дүнд хүрээгүй, "Пролианс" ХХК-ийн түншлэгч байгууллагын ирүүлсэн санхүүгийн тайлан нь иж бүрдэл дутуу болон орчуулгагүй, хуримтлагдсан ашгийн болон мөнгөн гүйлгээний тайлан дутуу, 2012 оны аудитаар баталгаажсан тайлан ирүүлээгүй, "Мед Монгол" ХХК-ийн ирүүлсэн саналыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 28 дугаар зүйлийн 28.7.4-д заасан "хамгийн бага харьцуулах үнэтэй тендерийг "хамгийн сайн" үнэлэгдсэн тендер гэж үзнэ" гэж заасны дагуу хассан, "Сүвэн Уул" ХХК-ийн тендерт ирүүлсэн тоног төхөөрөмжийн техникийн тодорхойлолт нь чанарыг хангаагүй, борлуулалтын орлогын хэмжээ хүрээгүй үндэслэлээр хасагдсаныг шалгуулахаар гомдол гаргажээ.

ТЕГ-ын ЭУГ-ын даргын 2013 оны 6/2167 дугаартай албан бичигт тендерт оролцогч "ЭМЖЖ ХХК 4.7 сая төгрөгийн, Космостек Монгол ХХК 0.4 сая төгрөгийн татварын өртэй, сүүлийн 3 жилийн "Эйч энд Эйч" ХХК-ийн борлуулалтын орлого 8 тэрбум төгрөг, , "Сүвэн Уул" ХХК-ийн борлуулалтын орлого 6.1 сая төгрөг болохыг тодорхойлсон нь ТООЗ-ны 18.1-д заасан борлуулалтын орлогын дүнд хүрээгүй ба "Пролианс" ХХК нь "сүүлийн 3 жилийн аудитаар баталгаажсан санхүүгийн ирүүлнэ", тендерийн хэл нь "Монгол хэл байна" гэсэн шаардлагыг хангаагүй гэж дурьдсан байна.

Аймгуудын нэгдсэн эмнэлгийн оношлогооны төвүүдийн засвар, тохижилтын ажил хүлээгдсэнээс оношлогооны төвүүдийн үйл ажиллагаа бүрэн эхлээгүй байна.

ЗГХЭГ-аас нэр бүхий 11 аймгийн Нэгдсэн эмнэлгийн оношлогооны төвүүдэд тус бүр 180.0 сая төгрөг нийт 1.9 тэрбум төгрөг төсөвлөж, засвар, тохижилтын ажлын гүйцэтгэгчийг шалгаруулах тендерийг орон нутагт яаралтай хугацаа алдалгүй зохион байгуулж, гүйцэтгэлийг Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан журамд нийцүүлэн баталгаажуулж ЗГХЭГ-т ирүүлэх тухай 2013 оны 11 дүгээр сарын 1-ний өдрийн ХЭГ/1706 тоот албан бичгийг хүргүүлсэн боловч зарим аймаг 2013 ондоо багтааж засварын ажил бүрэн дуусгаж чадаагүй байна. Тухайлбал:

Хэнтий аймагт оношлогооны төвийн барилгын их засварын ажлын гүйцэтгэл гараагүй байхад гүйцэтгэгч компанид гэрээний төсөвт өртөгийн 72.4 хувь буюу 107.6 сая төгрөгийн санхүүжилтийг 2013 оны 12 дугаар сарын 31-нд "Алтай Гоулд" ХХК-д аймгийн төрийн сангаас шилжүүлсэн;

Хөвсгөл аймагт "Хөвсгөл жугнай" ХХК барилгын засварын ажлыг тайлангийн 2.1-д дурьдсан гэрээний хугацаанд дуусгаагүй байна. Уг ажлыг хүлээж авах улсын комиссын актанд "2014 оны 2 дугаар сарын 6-аас эхэлсэн бөгөөд 2014 оны 2 дугаар сарын 25-ны өдөр дуусгасан байна" гэж тэмдэглэсэн байна.

"Хөвсгөл жугнай" ХХК гэрээнд заасан хугацаанд ажлаа эхлээгүй болон гэрээний хугацаанд ажлаа дуусгаагүй шалтгааныг тодруулахад:

Барилгын их засварын ажлын гэрээний биелэлтийг дүгнэсэн хурлын тэмдэглэлд "Хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй байсан, ажлын тоо хэмжээнд өөрчлөлт орсон зэргээс гэрээний хугацаа 5 хоногоор хэтэрсэн" гэж тусгасан;

Сэлэнгэ аймагт засварын ажил эхэлсэн ч барилга засварын ажил тухайн ондоо 70 хувийн гүйцэтгэлтэй байсан байна.

Улаанбаатар хотод эх, ураг, нярайн тусламж үйлчилгээний төв байгуулах төсөлд 2,420.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэх багц-1-ийн гүйцэтгэгчээр "Сүвэн уул" ХХК шалгарч 2014 оны 1 дүгээр сарын 6-нд нийлүүлэхээр 397.2 сая төгрөгөөр гэрээг байгуулан 2013 оны 12 дугаар сарын 26-нд хүлээлгэн өгсөн байна. Тус ажлын Ангиографи багц-2 ажилд "Монос фарм трейд" ХХК шалгарч 1,780.0 сая төгрөгөөр 2014 оны 3 дугаар сард хүлээлгэн өгөхөөр гэрээ байгуулан хугацаандаа хүлээлгэн өгчээ.

Харин ХААГ-аас зохион байгуулсан катетерийн лабораторын засвар, тохижилтын ажлын тендерийг 2 удаа нээлттэй зарласан боловч шаардлагад нийцсэн санал ирээгүйгээс хэрэгжээгүй байна.

ЗГХЭГ болон ХААГ нь Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолыг зөрчиж гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна

Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хугацаа нь Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолд заасан "Хөрөнгө оруулалтын ажлыг 2013 онд багтаан гүйцэтгэх боломж, ажлын стандарт, чанарт тавигдах шаардлага зэргийг харгалзан 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар гэрээ

байгуулагдаагүй байгаа шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эхлэх хугацааг хойшлуулах" гэж заасныг зөрчсөн байна. Тухайлбал:

Аймгуудын оношлогооны төвийн тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээнүүдийг 2013 оны 10 дугаар сарын 7-нд, Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ аймгуудын Эрүүл мэндийн төвийн засварын ажлын гэрээг 2013 оны 12 дугаар сарын 5, 9, 24-ний өдөр байгуулсан байна.

Бүлэг 2. ЭМЯ-ны хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөлттэй уялдаагүйгээс зарим хөрөнгө оруулалтын үр дүн гарахгүй байна

Засгийн газраас оношлогооны төв байгуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ шаардлагатай тоног төхөөрөмжийн судалгааг аймгийн Эрүүл мэндийн газар, Нэгдсэн эмнэлгээс аваагүй нь Төсвийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.6⁴ дахь заалт зөрчсөн байна. Тухайлбал:

Баянхонгор аймагт шаардлагатай эмнэлгийн тоног төхөөрөмжийн судалгааг жил бүр гаргаж ЭМЯ-д явуулдаг байсан талаар Эрүүл мэндийн газар болон Нэгдсэн эмнэлгийн удирдлага мэдэгдэж байхад 2013 онд ЭМЯ-д хүргүүлсэн тоног төхөөрөмжийн судалгааг Оношлогооны төвд нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийн жагсаалттай тулган үзэхэд зөөврийн рентгенээс бусад нь нэр төрлийн хувьд таарахгүй байсан болно.

Урьдчилсан судалгаа дутуугаас тоног төхөөрөмжийг дахин хуваарилжээ

Төлөвлөлтийн шатанд урьдчилсан судалгаа хийгээгүй, хэрэгцээ шаардлагыг бүрэн тодорхойлоогүйгээс 11 аймагт хуваарилсан тоног төхөөрөмжүүдийг Төрийн өмчийн хорооны 2014 оны 418 дугаар тогтоол, 2014 оны 336 дугаар тогтоолоор хуваарилсан хөрөнгөнөөс дараах хөрөнгүүдийг шилжүүлэн дахин хуваарилсан байна. Үүнд:

				/төгрөгөөр/
	Тоног төхөөрөмжийн нэр	Тоо ширхэг	Үнэ	Шилжүүлэн авах хуулийн этгээт
1	Рентген суурин дижитал төхөөрөмж	1	274,722,800.0	Улсын I төв эмнэлэг
2	Рентген зургийг дижитал болгон хувиргагч төхөөрөмж	1	72,187,500.00	Улсын I төв эмнэлэг
3	Авторефрактометр	1	8,690,000.00	Орхон аймгийн Бүсийн оношилгоо эмчилгээний төв
4	Хялар тодорхойлох багажны иж бүрдэл	1	550,000.00	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг
5	Нүдний даралт хэмжигч	1	2,750,000.00	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг
6	Диоптриметр	1	2,750,000.00	Булган аймгийн нэгдсэн эмнэлэг
			361,650,300.00	

Ашиглалтын шаардлагын дагуу дээрх өөрчлөлтийг хийсэн бөгөөд аймгуудад хуваарилсан тоног төхөөрөмжөөс өнөөгийн байдлаар ашиглаагүй тоног төхөөрөмжүүд ч бас байсаар байна. Тухайлбал: /Тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг хавсралт №2-оор үзүүлэв./

Дорноговь аймагт ЗГХЭГ-ын даргын 2014 оны 75 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар 2.1 тэрбум төгрөгийн 7 багц тоног төхөөрөмжийг нийлүүлэхээр заасан байна. Гэвч Төрийн өмчийн хорооны 2014 оны 7 сарын 3-ны өдрийн 418 тоот тогтоолоор Дорноговь аймгийн Нэгдсэн эмнэлэгт нийлүүлэгдэх байсан 86.8 сая төгрөгийн 5 нэр төрлийн тоног төхөөрөмжийг Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Орхон, Булган аймгуудын

⁴ “Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэ хуулийн 28.3.2, 28.3.3-т заасан эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг харгалзан үзэхэд үр дүнтэй болох нь урьдчилсан судалгаагаар тогтоогдсон нөхцөлд зураг, төсөв, техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоо хийнэ.”

Нэгдсэн эмнэлэгт тус тус шилжүүлжээ. Шалтгаан нь тухайн эмнэлэгт байгаа тоног төхөөрөмжийг дутагдалтай газруудад шилжүүлсэн гэсэн тайлбарыг холбогдох газрууд өгч байв.

Иймд тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг дахин явуулж, тоног төхөөрөмжүүдийг хэрэгцээ шаардлагатай газруудад дахин хуваарилж, иж бүрдлийг бүрэн хангуулж ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.

Цаашид аймгуудад хуваарилсан тоног төхөөрөмжийн иж бүрдлийг гүйцээж, урвалж оношлуурын зардалыг нэмэгдүүлж, хангамжийг сайжруулснаар эмчилгээ оношлогооны чанар, үр дүн сайжрах боломжтой байгаа бөгөөд хөдөө орон нутгаас нийслэл хот руу ирж, оношлогоо шинжилгээ хийлгэх иргэдэд учрах шууд болон шууд бус зардал, чирэгдэл багасч, орон нутагтаа оношлогоо эмчилгээ хийлгэх боломж бүрдэж байна. Тухайлбал:

Баянхонгор аймгаас Улаанбаатар хот руу явж эмчлүүлэгчдийн тоо өмнөх оноос 10 хувиар буурсан, Дорноговь аймаг 3 дахин буурсан, Сүхбаатар аймгийн хувьд 5.8 хувиар буурсан дүн гарчээ.

Оношлогооны төв байгуулсан аймгуудад дээрх нэр төрлийн тоног төхөөрөмжөөр оношлогоо эмчилгээг 2014 оны 4 дүгээр сарын 1-нээс эхлэн үзүүлж эхэлсэн бөгөөд мөн оны 9 дүгээр сарын байдлаар нийт 197.9 мянган иргэн, нэг аймагт дундажаар 18.0 мянган иргэн үйлчлүүлсэн гэсэн мэдээг ЭМЯ-аас гаргасан байна.

Орон нутагт оношлогоо, шинжилгээ хийх тоног төхөөрөмжүүд нийлүүлэгдсэн боловч түүнд ашиглагдах урвалж оношлуур нь өндөр үнэтэй байгаа тул олон нэр төрлийн шинжилгээ хийхэд төсөв, хөрөнгийн хэмжээгээр хүрэлцэхгүй байна

Аймгуудын Эрүүл мэндийн газар, ашиглагч байгууллага болох Нэгдсэн эмнэлгийн зүгээс олон улсын жишигт нийцсэн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн гэж байгаа боловч үүнийг нотлох боломжгүй байгаа ба зарим тоног төхөөрөмж ашиглалтын зардал өндөртэй, хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Мөн урвалж оношлуурын үнийг тогтвортой байлгах, орон нутагт урвалж бодисыг тасралтгүй хангах талаар нэгдсэн бодлого, зохицуулалт зайлшгүй шаардлагатай байна. Тухайлбал:

Хөвсгөл аймагт НЭ оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдэд шаардлагатай урвалж, оношлуурын жилийн хэрэгцээг тооцоолоход 673,544.2 мянган төгрөгийн урвалж, оношлуур шаардлагатай гэж гаргасан;

Сэлэнгэ аймагт Тоног төхөөрөмж, урвалж бодисыг худалдан авахын тулд Нэгдсэн эмнэлгийн эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн зардал 2013 онд 289.4 сая төгрөг байсан бол 2014 оны гүйцэтгэлээр 484.2 сая төгрөг, 2015 онд 733.0 сая болж өссөн байна.

Бүлэг.3. Эмч, мэргэжлийн техникийн ажилтнуудыг урьдчилан бэлтгээгүй, иж бүрдэл дутуу, урвалж оношлуурын өртөг өндөр, урсгал зардал нэмэгдсэнээс тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглаж чадахгүй байна.

Эмч, техникийн ажилтан байхгүйгээс өндөр үнээр худалдан авсан тоног төхөөрөмжөө ашиглахгүй байна.

Оношлогооны төвийн тоног төхөөрөмжүүдийг бүртгэл тайланд бүрэн тусгасан боловч зарим аймгуудад бэлтгэгдсэн эмч, техникийн ажилтан байхгүйгээс зарим тоног төхөөрөмж ашиглагдахгүй байна. Тухайлбал:

Архангай аймагт “Урологийн дурангийн иж” бүрдэл тоног төхөөрөмжийг ажиллуулах эмч мэргэжилтэн байхгүй, 2015 онд сургахаар төлөвлөжээ.

Баянхонгор аймагт Урологийн, Уушигны, Бүдүүн гэдэсний дурангууд бэлтгэгдсэн боловсон хүчин байхгүйгээс одоогийн байдлаар ашиглалтгүй байна.

Говь-Алтай аймагт Япон улсад үйлдвэрлэсэн Fujifilm EY-470SB маркын 133.9 сая төгрөгийн үнэ бүхий урологийн видео дуранг дагалдах хэрэгслийн хамт нийлүүлсэн ч ажилуулах мэргэжилтэнг бэлтгэж байгаа тул одоог хүртэл ашиглаагүй байна.

Хөвсгөл аймагт харааны талбай хэмжигч багажийг байрлуулах өрөөг шийдвэрлээгүйгээс ашиглалтгүй байна. Мөн урологийн видео дурангийн иж бүрдэлийг ажиллуулах эмч нь бэлтгэгдэж байгаа тул ашиглалтгүй байна.

ЭМЯ-аас зарласан тоног төхөөрөмж нийлүүлэх худалдан авах ажиллагаанд техникийн чанар, стандарт, техникийн шалгуур үзүүлэлт, иж бүрэн байдлыг тодорхой тусгаж өгөөгүйгээс шалтгаалан зарим багаж хэрэгсэл дутуу нийлүүлэгдсэнээс ашиглагдахгүй байна. Тухайлбал:

Сэлэнгэ аймагт “Чоногол трейд” ХХК-ийн нийлүүлсэн нүдний даралт хэмжигчийн суурь нь нийлүүлэгдээгүйгээс ашиглагдахгүй байна. Мөн нийлүүлсэн тоног төхөөрөмжийг тулгаж явцад харааны талбай хэмжигч багажийн удирдлагын товчлуур эвдэрсэн, завсрын ламп /биомикроскоп/ шатсан, шүдний дэлгэмэл рентген аппаратны туяаны хаялт өндөр, хүчдэлийн тохиргоо буруу хийгдсэнээс Цөмийн энергийн газраас зөвшөөрөл олгоогүй, шээсний анализаторын зориулалтын урвалжгүйгээс бүрэн хүчин чадлаараа ашиглагдахгүй байна.

Мөн Чоно гол ХХК-ийн нийлүүлсэн шүдний дэлгэмэл дижитал рентген аппарат, “Сетунари” ХХК-ийн нийлүүлсэн тархины судасны доплеграфы аппаратууд хэвлэгч төхөөрөмжгүй ирсэн нь бүрэн ашиглагдахгүй байна.

Дээрх тоног төхөөрөмжүүд нь хэвлэгчгүйгээс шалтгаалж өвчтөн дараагийн шатны эмнэлэгт шинжилгээ хийлгэхэд дахин рентген аппаратанд орох шаардлагатай болж байна. Оношлогооны тоног төхөөрөмжийн үнэ тарифийг батлаагүй, ихэнх тоног төхөөрөмжийн сэлбэг хэрэгсэл ирээгүй байна.

Мөн тоног төхөөрөмж нийлүүлсний дараа зарим нэг доголдол үүссэн байна. Тухайлбал:

Сэлэнгэ аймагт биохимийн анализаторийн шинжилгээний зүүний горим алдагдсаныг нийлүүлэгч Сетунари ХХК-аас холбогдох хүмүүс ирж засвар үйчилгээ хийж одоогоор хэвийн түвшинд ажиллаж байна. “Чоно гол трейд” ХХК шүдний дэлгэмэл рентген аппаратны хүчдэлийн тохиргоог буруу хийсэн, улирлын төлөвлөгөөт үйлчилгээг хугацаанд нь хийгээгүй байна. Аймгийн оношлогооны тоног төхөөрөмж дээр ажиллах эмч сувилагчийг Эрүүл мэндийн хөгжлийн төвд сургаж, дадлагажуулсан боловч урологи, уушигны дурангийн тоног төхөөрөмж ашиглах сургалт хийгдээгүйгээс уг аппаратаар оношлогоо, шинжилгээ хийгдэхгүй байна.

Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар нь дараах шалтгааны улмаас ашиглаж чадахгүй байна. Үүнд:

- Нүдний даралт хэмжигчийн суурь ирээгүй.
- Тоног төхөөрөмжийг бүрэн хэмжээгээр ажиллуулж, оношилгоо хийх мэргэжлийн боловсон хүчин урьдчилан бэлтгэгдээгүйгээс урологи, уушиг, ходоод, бүдүүн гэдэсний зэрэг хамгийн өргөн хэрэглээтэй дурангууд ашиглагдахгүй байна.

- Оношилгоонд ашиглагдах урвалж, рентген хальс зэрэг нь өндөр өртөгтэй учраас шээсний анализатор, дижитал рентген аппаратыг ашиглах боломж муутай байна.

Говь-Алтай аймагт нийлүүлсэн Япон улсад үйлдвэрлэсэн Fujifilm EB-530T загварын 59.8 сая төгрөгийн үнэ бүхий уушигний дуран нь ашиглахад бэлэн бөгөөд дурандах шаардлага одоогоор гараагүй байгаа гэсэн тайлбар холбогдох албан тушаалтан нар өглөө. Мөн Унгер улсад үйлдвэрлэсэн Elektronika LabUMat Urised маркын 50.0 сая төгрөгийн үнэ бүхий шээсний бүрэн автомат анализаторыг дагалдах хэрэгслийн хамт нийлүүлсэн ч уг тоног төхөөрөмж ашиглахад шаардагдах урвалж өртөг өндөртэй тул ашиглалтгүй байна

Хэнтий аймагт Ходоод, бүдүүн гэдэсний дуранг угааж, шалгах явцад гэмтэл гарч 2014 оны 3-р сард засварт явуулсан боловч ирээгүй, Рентген зургийг дижитал болгон хувиргагч /Fire CR80 HH-KH-01/ тоног төхөөрөмжийн туршилтын плёнк дууссанаас хойш дахин ирээгүй, плёнк нь өндөр үнэтэй зэргээс шалтгаалан ашиглахгүй байна.

Хөвсгөл аймагт Тархины доплерийн “тоног төхөөрөмжийн датчикын хүчин чадал нь муу, Герман улсынх биш Хятад улсын чанар муутай нь нийлүүлэгдсэн” гэсэн тайлбар өгсөн. Аймгийн НЭ-т нийлүүлэгдсэн 4D ЭХО аппарат нь 2D бөгөөд 4D болгон ажиллуулахын тулд дахин програм суулгах шаардлагатай байна.

Аудитын явцад авсан судалгаанаас үзэхэд урологийн дурангийн иж бүрдлийн эмч нийлүүлсэн 11 аймгийн 6-д нь бэлтгэгдээгүй, Сэлэнгэ аймагт нийлүүлсэн 16 төрлийн тоног төхөөрөмжийн 6-д эмч бэлтгэгдээгүй, 1 тоног төхөөрөмжийн оношлуур үнэтэй, 1 хэмжигч багаж зориулалтын суурьгүй, нийт 8 тоног төхөөрөмж ашиглагдахгүй байгаа нь урьдчилсан судалгаа хангалтгүй байгааг харуулж байна.

/Тоног төхөөрөмжийн ашиглалтын судалгааг хавсралт №2-оор үзүүлэв./

Дүгнэлт

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан хугацаа нь Засгийн газрын 2013 оны 324 дүгээр тогтоолд заасан 2013 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй нь шинээр эхлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний эхлэх хугацааг хойшлуулах тухай заалтыг зөрчсөн байна.
- Төслийг хэрэгжүүлэхдээ ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, тоног төхөөрөмжийн хангамжийн бодлоготой уялдаагүй, урьдчилсан судалгааг дутуу хийснээс тоног төхөөрөмжийг бүрэн ашиглахгүй байх, дахин хуваарилах нөхцөл бүрджээ.
- Тендер шалгаруулалтын шийдвэрт гомдол гаргах, тендер шалгаруулалт хүчингүй болох зэргээс шалтгаалан төсөл, арга хэмжээний хэрэгжилт удааширчээ.
- Аймгуудын нэгдсэн эмнэлгийн оношлогооны төвүүдийн засвар, тохижилтын ажил хүлээгдсэнээс оношлогооны төвүүдийн үйл ажиллагаа тодорхой хугацаагаар хойшилсон байна.
- Эмч, мэргэжлийн техникийн ажилтнуудыг урьдчилан бэлтгээгүй, иж бүрдэл дутуу, урвалж оношлуурын өртөг өндөр, урсгал зардал нэмэгдсэнээс тоног төхөөрөмжүүдийг бүрэн ашиглаж чадахгүй байна.
- Нийлүүлсэн тоног төхөөрөмжийн иж бүрдэл дутуу байгаа нь худалдан авах тендер зарлахдаа техникийн чанар, стандарт, шалгуур үзүүлэлт, иж бүрдлийг тодорхой тусгаж өгөөгүйтэй холбоотой байна.

Зөвлөмж

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын даргад:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн төслийг боловсруулахдаа ТЭЗҮ, зураг төсөв, хэрэгжих нөхцөл боломжийг урьдчилан судалж, шийдвэрлэж байх.

Эрүүл мэнд, спортын сайдад:

- Шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд 11 аймагт нийлүүлсэн оношлогооны тоног төхөөрөмжийн ашиглалтад үнэлгээ хийж, иж бүрдэл дутуу, гэмтсэн, тохиргоо дутууг гүйцэтгэгч байгууллагаар гүйцэтгүүлэх арга хэмжээ авч, ашиглалтыг сайжруулах,
- Эмч, мэргэжлийн техникийн ажилтнуудын сургалтыг холбогдох байгууллагуудтай хамтран яаралтай зохион байгуулах,
- Оношлогоо, эмчилгээнд шаардлагатай урвалж, оношлууруудын болон бусад шаардлагатай урсгал зардлын асуудлыг шийдвэрлэж байх,